



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №22



2019 оны 7 дугаар сарын 22-26

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **813** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 103(12.7%) галзуугийн эрсдэлд өртсөн, 689(85%) хачигт халдвар, 5(0.6%) боом, 6(0.7%) тарваган тахал, 2(0.2%) хумхаа, 1(0.1%) ям, 2(0.2%) денги, 3(0.4%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 103 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17%-иар, эпидемиологийн 29 дүгээр долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (38.8%), чононд (18.4%), эзэнгүй нохойд (14.6%), үнэгэнд (8.7%), үхэрт (7.8%), мануулд (2.9%), мууранд (1.9%), тэмээнд (1.0%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 689 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 29.5%-иар буурсан байна. Эпидемиологийн 29 дүгээр долоо хоногтой харьцуулахад адил үзүүлэлтэй байна.




2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар ХР-ын 571 сэжигтэй тохиолдлын 108(18.9%), ХБ-ын 51 сэжигтэй тохиолдлын 13(25.5%), ХЭ-ын 67 сэжигтэй тохиолдол 12(17.9%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

1.3 Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

2019 оны 7 дугаар сарын 23-нд Ховд аймгийн Үенч сумаас тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол мэдээлэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн. (Клиникийн онош: Хр. Бронхит, ангина)

1.4 Тарваган тахлын дархлаажуулалтын хамралт:

Тарваган тахлын дархлаажуулалтад 17 аймаг 9 дүүргийн 28441 хүний хамруулж, 93.1%-ийн хамралттай байна.



1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийслэлийн 4 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД) хэмжээнд нийт 30 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Өнгөрсөн хоногт нийслэлийн СХД-ээс ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) дуудлаганд үйлчилсэн. Сорьцод онош тодруулахаар лабораторийн шинжилгээ хийж байна.

Монгол улсад:

Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Хилэнтий гүүр, 14-р багийн хэмжээнд нийт 3 удаагийн ирүүлсэн мэрэгч амьтны (тарвага) дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материал шинжилгээний шаардлагагүй хангаагүй тул устгаж, халдваргүйтгэл хийсэн байна.


Эх сурвалж: Хөвсгөл аймгийн ЗӨСТ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 2522 тохиолдол бүртгэгдсэнээс 1698 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1423 (56%) нь эмэгтэйчүүд, 720 (29%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

MERS-CoV-ийн халдвар:

2019 оны 6 дугаар сарын 1-ээс 30-ныг хүртэлх хугацаанд Саудын Араб улсын 4 (Al-Qassim, Eastern, Riyadh, Madinah) дүүргээс 7 батлагдсан тохиолдол, 1 нас баралт бүртгэгдсэн байна.



Эх сурвалж: ДЭМБ

Хонины цэцэг өвчин:

Казахстан улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 6 дугаар сарын 15-нд Атыгайская мужийн аж ахуйд хонины цэцэг өвчний дэгдэлт бүртгэгдсэн байна.

Нийт 13486 хонь өртөмхий байснаас, 260 хонь өвчилж, 260 хонийг устгасан тухай Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн байна.




Эх сурвалж: ДМАЭМБ

Гахайн сонгомол мялзан өвчин:

Япон улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 7 дугаар сарын 02-нд Эна хотын Гифу тосгоны гахайн аж ахуйд, гахайн сонгомол мялзан өвчин бүртгэгдэж 4810 гахай өвчилсөн байна.

Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	• БНХАУ • Шичуан муж	2019.07.20	2019.07.11	Аж ахуй		21 гахай	81 гахай
ДМАЭМБ	• Украин • Кировоград тосгон	2019.07.23	2019.07.19	Аж ахуй	222 гахай	1 гахай	221 гахай
ДМАЭМБ	• Латви • Жаунжэйлгавис тосгон	2019.07.23	2019.07.21	Аж ахуй			1 зэрлэг гахай
ДМАЭМБ	• Польш • Мазовескэй тосгон	2019.07.23	2019.07.21	Аж ахуй	13 гахай	2 гахай	11 гахай
ДМАЭМБ	• Белги • Люксембург тосгон	2019.07.23	2019.07.16	Ойд			1 гахай

Эх сурвалж: ДМАЭМБ